ХУДГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

№	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчийн санал
1	**Цооног өрөмдөх, цооногийг тоноглох**	
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох	
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: 0,8 л/сек дээш байх	
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй	
1.8	Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй	
1.9	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх	
1.10	Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох	
1.11	Цохилтод өрмөөр өрөмдсөн тохиолдолд цооногийн нийт гүнд хамгаалалтын хуванцар хоолой хийнэ.	
2	**Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих**	
2.1	Худгийн байшингийн • Хэмжээ /дотор талдаа/: 3м х 3м, ханын өндөр шалнаас дээш 2 м • Материал: контаниар Ханыг цагаан өнгөөр будна. • Худгийн дээвэр бага зэргийн налуу, ус тогтхооргүй • Худгийн цонх нь 20см х 20 см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана/ • Худгийн хаалга нь 1.5-2мм –ийн зузаантай давхар лист төмрөн самбартай, 3 нугастай хаалга байна. • Байшинг рам зангидаж 2см-ын хавтангаар доторлосон байна	
2.2	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай, худгийн **шалнаас 60 см-ийн өндөрт** гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах	
2.3	Ундны ус авах хоолой нь: 60 мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/	
2.4	40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.	
2.5	Босоо суурьтай тоноглогдсон, ундны усанд зориулагдсан угсардаг 1,5м^3-ээс багагүй багтаамжтай нөөцийн сан, дээгүүрээ тагтай **нөөцийн сангийн доод хэсэг нь шалнаас 70 см өндөртэй** /1 тн-ын цагаан сав зөвшөөрөхгүй/	

2.6	Мал услах онгоцны: • **Хэмжээ: 9м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой, 3.0 мм-ийн зузаантай лист төмрөөр хагас цилиндр хэлбэртэй /онгоцны дээд ирмэг газраас 50 см өндөр байна/** • Мал услах онгоцны доод хэсэг газраас 20 см байна • Материал: 3 мм зузаантай лист төмөр, цутгамал бетон • Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана. • Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.	
2.7	Мал услах талбай: • Хэмжээ: Нийт мал услах онгоцны урт, өргөний дагуу 4 талдаа 2 м-ийн өргөнтэй, 15 см-ийн зузаантай цемэнтээр цутгасан талбай байна. • Материал: Хайрга, цемэнт • Услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэхэд тохиромжтой байна.	
3	**Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах самбар**	
3.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх	
3.2	Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2 м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно.	
3.3	Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай.	
3.4	Бага оврын генеротор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх	
4	**Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх**	
4.1	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/	
4.2	Худаг , гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх, талбайн сургалт хийх	
4.3	Худгийн паспорт бэлтгэх	